



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДЭД

2021.07.02 № 03/1710  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Шинжээч сонгон шалгаруулах  
урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн тогтолцооны өнөөгийн байдал, хүнсний чанар, стандарт, хүртээмжийн нөхцөл байдалд мэргэжлийн аргаар судалгаа шинжилгээ хийлгэн, санал зөвлөмж боловсруулах зорилгоор дараах зөвлөх үйлчилгээний шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Үүнд:

- “Монгол орны хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоонд судалгаа, дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замын талаар санал боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх”
- “Хүнсний бүтээгдэхүүний импорт, түүнд тавих хяналт, нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замын талаар санал боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх”
- “Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтад тавигдаж буй стандарт, түүний мөрдөлтөд тавих хяналтын орчинд судалгаа, шинжилгээ хийж сайжруулах арга замын талаар санал боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх”

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээний хүрээнд холбогдох ажлын даалгаварт тусгагдсан ажилбаруудыг хэрэгжүүлж, аудитын төлөвлөлт, талбарын үе шатанд шаардлагатай мэргэжлийн, шинжлэх ухааны үндэслэлтэй санал, дүгнэлт бэлтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан гаргаж, зөвлөмж боловсруулах ба зөвлөх үйлчилгээг 3 хүртэл сарын хугацаанд гүйцэтгэх ба, Монгол Улсад мөрдөгдөж буй хүнсний салбарын норм, норматив, стандарт, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хамруулна.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;

- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2018,2019,2020 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2019, 2020 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/:

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:

Хүүлийн этгээдийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх;
- Хүнсний салбарын хууль, дүрэм, журам, норм, нормативын баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан туршлагатай байх;
- Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан туршлагатай байх;
- Судалгаа, эрдэм шинжилгээний үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байх;
- Өөрийн судалгаа, шинжилгээний лабораторитой байвал давуу байдал болно:

Ажиллах хүчний шаардлага:

- Хүнсний аюулгүй байдлын талаар судалгаа хийж, дүн шинжилгээ боловсруулах мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Хүнсний мэргэжлээр /Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, Хүнс үйлдвэрлэлийн технологи, Хүнс үйлдвэрлэлийн технологи эрүүл ахуй, Хоол зүй, тэжээхүйн ухаан, эрүүл ахуйч гэх мэт/ болон бусад нарийн мэргэжлийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай байх.
- Мал эмнэлгийн болон газар тариалангийн чиглэлийн нарийн мэргэжлийн ажилтнуудтай байх.

Хувь хүн/баг/ бол:

- Зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх;
- Хүнсний салбарын хууль, дүрэм, журам, норм, нормативын баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан туршлагатай байх;
- Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан туршлагатай байх;
- Судалгаа, эрдэм шинжилгээний үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байх;
- Багийн ахлагч болон гишүүд нь хүнс, хүнс үйлдвэрлэлийн чиглэлийн болон агрономич, мал эмнэлэг, судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлийн нарийн мэргэжил эзэмшсэн байх;
- Багийн гишүүд нь гүйцэтгэх ажлын дэд зорилт тус бүрд тусгагдсан салбар чиглэлээр мэргэшсэнийг нотлох баримт бичигтэй байна.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба Түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай. /Гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үүргийг тусгасан байна/

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 09 цаг 00 минутын дотор цахим /pdf файл/ хэлбэрээр дараах хаягаар илгээнэ үү. Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. [tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn). Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, Үндэсний Аудитын газар, Утас: 26 35 33. [www.audit.mn](http://www.audit.mn)

ТАМГЫН ДАРГА



Ц.ГАНБОЛД